



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 03

Улаан-Уул сум

**Сонгуулийн сурталчилгааны зурагт самбар
байрлуулах байршил тогтоож, нийтэд
мэдээлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тус суманд 2024 онд зохион байгуулагдах Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн сурталчилгааны зурагт хуудсыг байрлуулах нэгдсэн самбарыг Төгөл багт цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн хойд буланд 1 дүгээр цэгийг $50^{\circ}40'37.22''N$, $99^{\circ}13'37.84''E$, 2 дугаар цэгийг $50^{\circ}40'37.40''N$, $99^{\circ}31'38.19''E$ байршлын солбилцолд, зурагт хуудсыг Агьт тун эмийн сангаас доошоо замын уулзвар хүртэл нам, эвслүүд 5, 5 метрийн зайтай байхаар тогтоосугай.

2.Тогтоосон байршлыг ард иргэдэд мэдээлж, сонордуулсугай.

3.Заасан газруудад намууд болон бие даагч нар зурагт самбараа байрлуулж, хуулийн дагуу сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж ажиллахыг нам, эвслийн дарга нарт даалгасугай.

4.Төрийн байгууллагуудын дэргэдэх мэдээллийн самбар, банкууд, гүний худаг, дэлгүүрүүдийн хаалга зэрэгт сурталчилгааны зурагт болон ухуулах хуудсыг байрлуулахыг хориглосугай.

5.Гарсан тогтоолын хэрэгжилтэд сонгуулийн хугацаанд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Б.БҮРЭНЧӨДӨР

D:\ИТХ-ын тогтоол.docx

6737001003